



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/489

Мөрөн сум

Газар үнэгүй өмчлөх эрхийг
дуусгавар болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 31.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Аюуш овогтой Бат-Эрдэнэ /НБ165112575/ -нь өөрийн хүсэлтээр газар өмчлөх эрхээсээ татгалзаж байгаа тул аймгийн Засаг даргын 2005 оны 4 дүгээр 30-ний өдрийн №90 дугаар захирамжийн хавсралтын 88 дугаар заалт, 2013 оны 10 сарын 9-ний А/237 дугаар захирамжийн хавсралтын 2 дугаар заалтуудыг хүчингүй болгож Монгол улсын иргэнд нэг удаа газар үнэгүй өмчлөх эрхийг дуусгавар болгосугай.

2.Мөрөн сумын Засаг даргын 1999 оны 03 сарын 31-ний өдрийн №18 дугаар захирамжийн Аюуш овогтой Бат-Эрдэнэ /НБ165112575/-ийн холбогдох заалтыг хүчин төгөлдөр хэвээр үлдээсүгэй.

3.Хувийн хэргийн бүрдүүлэлтийг ханган, өмчилсөн газрыг улсын бүртгэлийг өөрчлөн бүртгэж мэдээллийн санд өөрчлөлтийг тусган захиргааны актыг оролцогчдод мэдэгдэхийг Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-д эрхийн баталгаанд өөрчлөлт хийхийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус даалгасугай.

4.Аймгийн Засаг даргын энэхүү шийдвэрийг оролцогчид эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5.Газар эзэмшигчийн үүргийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр)-д даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

